



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 14 өдөр

Дугаар A/166

Ховд

Г

Г

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Шинэ халуун ус, үйлчилгээний төв байгуулах /Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Цогтбаяр -Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: С.Мөнх-Очир -Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Ж.Ганболд - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Х.Жангарзүсэм - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:
Ж.Батлхагва -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо / Ц.Цогтбаяр/-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Ж.Батлхагва /-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД

2019 Т A/166 Ch
02 00329



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 17 өдөр

Дугаар A/68

Ховд

Г Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.1.5 дахь заалтийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Баруун бүсийн өрсөлдөх чадварын чуулган”-ыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга: Ц.Ганданповрон – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Б.Ганболд – Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Д.Даваадорж – Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Батнасан – Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Л.Батгэрэл - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Түмэндэмбэрэл - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ц.Даваасамбуу – Аймгийн орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Н.Эрдэнэцэцэг - Аймгийн орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Т.Анхбаяр – Аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Х.Мөнхзолбоо - Аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн